

ГАМШГИЙН ҮЕИЙН АР ТАЛ ХАНГАЛТЫН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ЗАРЧИМ, ТҮҮНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

*Онцгой байдлын сургуулийн Гал
түймэртэй тэмцэх албаны тэнхимийн дэд
профессор, хошууч Л.Булганхангай*

Хураангуй

Ар талын хангалт нь цэргийн байлдааны бэлэн байдал, өдөр тутмын үйл ажиллагааг хангах, даалгасан үүргийг биелүүлэхэд чиглэсэн цэргийн материалын, тээврийн ба бусад аж ахуйн хангалт, үйлчилгээний арга хэмжээний нэгдэл; цэргийн байлдааны ажиллагааны нэг төрөл юм. Ар тал хангалт нь материал хэрэгслийн, тээврийн, инженер-аэродромын, аэродром-техникийн, хүн эмнэлгийн, мал эмнэлэг-эрүүл ахуйн, худалдаа, ахуйн үйлчилгээний, орон сууц санхүүгийн хангалтуудыг өөртөө багтаана.

Онцгой нөхцөл байдлын үед албан хаагчдыг зэвсэг, техник, ар талын материал хэрэгслээр хангах, тээвэрлэх, аврах багажаар хангах, өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг гамшгийн голомтоос татан гаргах зорилгоор бий болгосон хүч хэрэгслийн бүлэглэлийг онцгой байдлын албаны ар тал гэнэ.

Түлхүүр үг: Гамшиг, ар тал хангалт, материал, хуьцас хэрэгсэл, машин, техник, осол, гал түймэр,

ОРШИЛ

Ар тал хангалт гэдэг нэр томъёог дэлхийн II дайны үеийн байлдааны талбарт “хангамж ба тээвэрлэлт” гэдэг ойлголтоор ашиглаж эхэлсэн. Ар тал хангалт гэдэг нь материал, техник хэрэгслийн хангалтыг зөв тоо хэмжээгээр, оновчтой захиалгаар, сайн чанар байдалтайгаар, шаардлагатай газарт нь зохих цаг хугацаанд худалдан авч нийлүүлэх, хуваарилан хүргэх үйл ажиллагаа³⁰ юм.

Онцгой нөхцөл байдлын албаны бүх талын хангалт нь аврах ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд захирагч штабаас аврагчдыг аврах ажиллагаанд цагт нь зохион байгуулалттай оролцох аврах ажиллагааг амжилттай явуулах таатай нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн төрөл, тусгай мэргэжлийн дэмжлэг болон хангалтын хүч хэрэгслийн нягт ажиллагааг хангах зорилгоор хэрэгжүүлж буй арга хэмжээ³¹ юм.

³⁰ Ник Картер, Гамшгийн менежмент гарын авлага, Англи хэлнээс орчуулсан хэвлэл, УБ хот, 2005 он, 257 дахь тал.

³¹ Цэдэв.П, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” ЭШӨ, 2015 он

Гамшгийн үеийн ар тал хангалт гэдэг нь: Гамшгийн онцгой нөхцөл байдлын үед шаардлагатай техник, багаж хэрэгсэл, ар талын хангалтын материалуудыг аврах ажиллагааны бүсэд шуурхай хүргэх, нэрвэгдэгсдийг татан гаргах, эмнэлгийн тусламж үзүүлэх үйл ажиллагааг нарийн тооцоололтойгоор удирдан зохион байгуулах үйл ажиллагааны нэгдэл гэж тодорхойлж болох юм.

Монгол Улсын гамшгаас хамгаалах тухай хуулийн 4.1.19."гамшгийн онцгой нөхцөл байдал" гэж аюулт үзэгдэл, ослоос үүдэн хүний амь нас, эрүүл мэнд, мал, амьтан, хүрээлэн байгаа орчин, дэд бүтцэд ноцтой хохирол учруулж, хүн-нийгэм-эдийн засгийн аюулгүй, тогтвортой байдал, хэвийн үйл ажиллагаа алдагдахыг³² хэлнэ гэж тодорхойлсон байна.

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 24.1-т техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бараа материал нь ар тал хангалтын үндсэн тулгуур ойлголтыг гаргаж өгсөн нь бидний судалгааны ажлын үндсэн ойлголттой шууд холбогдож байна³³.

Аврах ажиллагааны бүрэлдэхүүнд багтаж, аврагчдын эрүүл мэнд, зэвсэг техникийн бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадварыг тасралтгүй хангах зорилгоор бүрдүүлсэн материал хэрэгслийн нөөц бүхий эмнэлгийн, засвар татан гаргалтын, тээврийн, аж ахуйн зориулалтын хүч хэрэгслээс бүрдсэн ар тал техникийн анги салбаруудын үйл ажиллагаа, үйлчилгээний хүрээ юм.

Гамшиг ослын үед болон тайван цагт Онцгой байдлын албаны ар талын хангалтыг зохион байгуулах үйл ажиллагаа нь улс орны эдийн засгийн чадавх, зэвсэглэмж, техник технологийн шинэчлэлийн төвшин, тайван цагт бүрдүүлсэн материал хэрэглэлийн нөөцийн хэмжээ, тэдгээрийн зохистой байршуулалт, ар талын бие бүрэлдэхүүний мэргэжлийн ур чадвар, ар талын техник, хүч хэрэгслийн хангалтын байдал зэрэг олон хүчин зүйлээс хамаардаг.

Онцгой байдлын ар талын үндсэн үүрэг нь аврах үйл ажиллагааг ямарч нөхцөлд явуулахад зэвсэг техник, ар талын материал хэрэгслээр тасралтгүй хангах, өвчтөн шархтанд эмнэлгийн тусламж үзүүлэх, тэдгээрийг гамшгийн голомтоос татан гаргах явдал юм³⁴.

Онцгой байдлын удирдлага бол захирагч, штаб болон удирдлагын бусад байгууллагууд цагийн байдлын тухай мэдээлэл авч судлан шинжилж нягтлан, шийдвэр гаргаж гүйцэтгэгчид нь хүргэх замаар аврах ажиллагаанд бэлтгэх болон аврах ажиллагааны явцад анги, салбарын хүчин

³² Гамшгаас хамгаалах тухай хууль, Уб 2017 он

³³ Гамшгаас хамгаалах тухай хууль, Уб 2017 он

³⁴ Цэдэв.П, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” гарын авлага

чармайлтыг аврах үүргээ амжилттай биелүүлэхэд чиглүүлэх зүй зохистой үйл ажиллагаа байдаг.

Ар талын удирдлага бол Онцгой байдлын удирдлагын үндсэн бүрэлдэхүүн хэсэг тул аврах ажиллагаанд зэвсэг техник, ар талын материал хэрэгсэл, эрүүл мэндийн хангалтыг зохион байгуулж явуулахад захирагч, штаб, ар талын дарга, төрөл, мэргэжлийн албадын дарга нараас явуулж буй үйл ажиллагаа болно. Ар талыг бэлэн байлгах, бэлтгэх, ар талын өмнө тавигдсан үүргийг биелүүлэх явцад түүнийг удирдах үйл ажиллагаа нь цогц бөгөөд чиг үүргийн хувьд харилцан уялдаатай.

Ар тал хангалт гэдэг нь зөв хангалтыг зөв тоо, хэмжээгээр, оновчтой захиалгаар, сайн чанар байдалтайгаар, зөв газар зохих цаг хугацаанд худалдан авч нийлүүлэх, хуваарилан хүргэх үйл ажиллагаа юм.

Хөнөөл уршгийг арилгах арга хэмжээний тодорхой үүрэг гүйцэтгэх үед газар, агаар, усан замаар хөдөлгөөн ихээхэн үйлдэх шаардлагатай байдгаас гадна аврах бүлэг хэсэг бэлтгэл ажлаа хангахын тулд үндсэн бааз дээрээ нэлээд үйл ажиллагаа явуулдаг байна.

Аврах хөнөөл уршгийг арилгах ажиллагаанд төрөл бүрийн тээврийн хэрэгсэл, завь, нисэх онгоц шаардагддаг тул тэдгээрт төрөл бүрийн хангалт хэрэгтэй болдог. Үүнд:

- Шатах тослох материал
- Техникийн сэлбэг, тоног төхөөрөмж
- Хүнсний зүйл , эм эмнэлгийн хэрэгсэл, майхан сав гэх мэт хүн нэг бүрийн эд хэрэгсэл
- Захиргаа аж ахуй, бичиг хэргийн эд гэж тодорхойлсон байна

Б.Дондог, Ж.Намнан нарын “Цэргийн ар тал хангалт” сурах бичигт авто техникийн хангалтыг дараах байдлаар тодорхойлохдоо:

Авто техникийн хангалтад автомашинууд /хөнгөн, ачааны, тусгай/, их бууны чирэгч /дугуйт, гинжит/, трактор, чиргүүл, унадаг дугуй, тэдгээрийн сэлбэг, анги, агрегатууд, авто техник засвар үйлчилгээ хийх засварын байр, резин-азбест, тоноглол багаж хэрэглэл болон техникийн үйлчилгээ засварын бусад материалууд хамаарагдана³⁵.

Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах тусгай зориулалтын тоноглол бүхий автомашинд тавих ерөнхий шаардлага CS 11-0425:2019 стандартад: Гал унтраах автомашин: Гал түймэр унтраах зориулалттай тусгай тоноглол бүхий автомашин.

Гал түймэр унтраах тоноглол бүхий автомашины ангилал

³⁵ Намнан.Ж Цэргийн ар тал, Уб., 1995, х.-56

1. Гал унтраах үндсэн албаны автомашин

- Гал түймэр унтраах үндсэн албаны автомашиныг *бага, дунд, том оврын* гэж 3 ангилна.

2. Гал түймэр унтраах тусгай албаны автомашин:

- Авто механик шаттай автомашин
- Гэрэл, холбооны автомашин
- Утаа сорогч автомашин
- Амьсгалын бие даасан төхөөрөмжийн автомашин
- Хоолойн албаны автомашин
- Гал түймэр унтраах удирдлагын штаб автомашин
- Ой хээрийн түймэр унтраах автомашин

3. Гал түймэр унтраах туслах албаны автомашин:

- Ус тээвэрлэгч автомашин.

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг хангах асуудлын нэн чухал хэсэг бол гал түймэр унтраах бодисын нөөцийн асуудал тул гал унтраах бодисыг ус, хөөс, нунтаг зэргээр ангилдаг. Гал унтраах бодисоос түгээмэл хэрэглэгдэж байгаа бодис нь ус юм. Тиймээс усан хангамжийн асуудал нь ангийн үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт байгаа усан хангамжийн судалгааг гаргаж тодотгон бэлэн байдлыг ханган ажиллах байдалтай шууд хамааралтай.

Аврах гал түймэр унтраах үйл ажиллагааны үед зохион байгуулагдах ар талын хангалт, томьёоллын бие даасан төхөөрөмжийн засварын хэсэг зэрэг олон төрлийн үйл ажиллагаа тус арга хэмжээнд хамаарна.

Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын хангалтад дараах асуудлыг авч үздэг. Үүнд:

- Томилгоот бүрэлдэхүүний хувцас, хэрэглэл
- Автомашин техник, хэрэгсэл түүний сэлбэг
- Холбооны хэрэгсэл
- Хүнсний зүйл
- Шатахуун
- Эм бэлдмэл, анхны тусламжийн хэрэгсэл
- Гал түймэр унтраах бодис
- Захиргаа аж ахуй, бичиг хэргийн эд зүйлс хамаарна.

Ар талын удирдлагын үндсэн зорилго нь аврах үйл ажиллагаанд тавигдсан үүргийг биелүүлэхийн тулд цагийн байдлын тодорхой нөхцөлд ар талын хүч хэрэгслийг дээд зэргээр үр бүтээлтэй ашиглах нөхцөлийг хангах үйл ажиллагаа байдаг тул үндсэн агуулгад хэд хэдэн арга хэмжээ хамаарагдана. Үүнд:

- Ар талын хангалтыг зохион байгуулах саналыг цаг тухайд нь хэрэгжих үндэслэлтэйгээр гаргаж, гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэгч нарт маш богино хугацаанд хүргэх
- Аврах үйл ажиллагаанд ар талын хангалтыг төлөвлөх
- Харьяа анги, салбарт тавигдсан үүрэг хүргэх
- Удирдлагын ар талын байр болон ар талын харьяа анги, салбаруудын харилцан ажиллагаа, хангалтын уялдаа холбоог зохион байгуулах
- Аврах үйл ажиллагаанд бэлтгэх түүнийг зохион байгуулж явуулах үед ар талын төрөл бүрийн хэрэгслийг ашиглаж тасралтгүй удирдах
- Цагийн байдлын мэдээг тасралтгүй олох, цуглуулах, судлах, тогтоох
- өгөгдсөн үүргийн гүйцэтгэлийг хянаж, туслалцаа үзүүлэх зэрэг болно.

Ар талын удирдлагын үндсэн агуулгыг хангахын тулд ар талыг бэлэн байдлын өндөр төвшинд байлгах, удирдлагын ар талын байр болон ар талын анги, салбарын удирдлагын байрын тогтвортой ажиллагааг хангах, цагийн байдлын мэдээг цуглуулах, удирдлагын ба холбооны хэрэгслийг үр бүтээлтэй ашиглах, албан тушаалтнуудын ар талын мэдлэгийг гүнзгийрүүлэх, ажлын арга барилыг амьдралд нэвтрүүлэх, аврах үйл ажиллагааны удирдлагыг нарийн зохион байгуулах шаардлагатай болдог.

Ар талын хангалт нь дараах зарчмуудтай байна³⁶. Үүнд:

1. Албаны бэлэн байдал болон бэлэн байдлын зэргүүдэд шилжихэд байнга бэлэн байх
2. Хүч хэрэгслийг зөв хувиарлан ашиглах чадвартай байх
3. Тасралтгүй бүрэн хэмжээгээр тухай бүрд нь хийгдэж байх
4. Зөрчил гарч болзошгүй чиглэлд төвлөрүүлж, төлөвлөгдсөн байх
5. Арвилан хэмнэлтийн зарчимд тулгуурлагдсан байх
6. Материал хэрэгслийн нөөцийг бүрдүүлсэн байх
7. Хүч хэрэгсэл сургагдсан, ашиглах чадвартай маневарлах хугацааг зөв сонгож хийж чаддаг байх
8. Удирдлагын тогтвортой байдлыг өндөр төвшинд байлгах зэрэг болно.

Ар талын удирдлага нь Онцгой байдлын албаны удирдлагын нэгэн адил өндөр бэлэн байдалтай, шуурхай бүтээлч ажиллагаатай, бат тогтвортой байх шаардлагатай. Ар талын удирдлагад дараах шаардлагууд тавигдана. Үүнд:

- Тасралтгүй байх

³⁶ Төрмөнх.Ц, “Цэргийн ар тал, техникийн хангалтын үндэс” гарын авлага

- Хатуу чанд байх
- Уян хатан байх

Эдгээр шаардлагууд нь доорх үйл ажиллагааг нарийн чанд төлөвлөгөөтэй хэрэгжүүлснээр хангагдана. Үүнд:

Тасралтгүй байх нь:

- Захирагч штаб, удирдлагаас тавигдсан үүргийг амжилттай хэрэгжүүлэхэд байнга нөлөөлөх
- Аврах болон холбоо мэдээллийн найдвартай техник хэрэгсэлтэй байх
- Алдагдсан удирдлагыг богино хугацаанд сэргээх чадвартай байх
- Цагийн байдлын тухай мэдээг тасралтгүй авах боломжтой.

Хатуу чанд байх нь:

- Гаргасан шийдвэрийг шуурхай хэрэгжүүлэх
- Шийдвэртэй, зоригтой арга хэмжээг хэрэгжүүлэх
- Албан хаагчдашүдаа өндөр шаардлага тавих
- Хамт олныг тавигдсан үүргийг биелүүлэхэд чиглүүлэх.

Уян хатан чанар нь:

- Цагийн байдлын өөрчлөлт бүрд тасралтгүй удирдах өөрчлөлтийг урьдчилан төсөөлөх, таамаглах мэдрэмжтэй байх
- Удирдлагыг нэг байрнаас нөгөөд шуурхай шилжүүлэх боломжийг хайх гарцыг нээх
- Холбоо удирдлагын хэрэгслийг чадварлаг ашиглах цагийн байдлын ямар ч нөхцөлд удирдлага бэлэн байх зэрэг болно.

Онцгой байдлын албаны ар талын хангалтын үндсэн үүрэг нь³⁷:

- Албаны бэлэн байдлыг хангаж тавигдсан үүргийг хангах чадвартай байх
- Хүнсний хангалтыг зохион байгуулах
- Орон сууц, хувцасны хангалтыг зохион байгуулах
- Аврах багаж техник хэрэгслийн хангалтыг зохион байгуулах
- Материал хэрэгслийг бэлтгэх, татан авах, хадгалах, хадгалалтыг зохион байгуулж, нөөцийг байнга бүрдүүлж, сэлгэлт хийх, тээвэрлэх ажлыг зохион байгуулах чадвартай байх
- Хүн эмнэлгийн тусламж үзүүлэх өвчтөн шархтанг тээвэрлэх, зөөх үүргийг хэрэгжүүлж чаддаг байх
- Материал хэрэгслийг худалдан авах, тендер зарлах, гэрээ хэлцэл байгуулах арга хэмжээг зохион байгуулах

³⁷ Цэдэв.П, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” ЭШӨ-2015 он.

- Хүнсний болон мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэлд ариун цэврийн ба хорио цээрийн үзлэг хийх, хяналт тавьж байх
- Ар талын хангалтын хүч хэрэгслийг сургаж дадлагажуулах
- Техникийн албыг удирдан зохион байгуулж, түүний ашиглалт эзэмшилтэд хяналт тавих
- Мал аж ахуй болон албаны амьтдыг арчлан хамгаалах ажлыг зохион байгуулах
- Эрчим хүч, дулааны хангалтыг зохион байгуулж, түлшний хангалтыг хийх
- Ундны усаар хангах, ус хангалтыг зохион байгуулах
- Нийгмийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмнэлэг ариун цэврийн хяналт зохион байгуулах
- Цалин санхүүгийн хангалтыг зохион байгуулах
- Ар талын хангалтыг төлөвлөх, удирдан зохион байгуулж явуулах арга хэмжээг хэрэгжүүлэх
- Техникийн болон материалын хангалтыг зохион байгуулах зэрэг үүргийг гүйцэтгэнэ.

Ар талын хангалтын бэлэн байдал гэдэг нь аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбаруудыг цагийн байдлын ямар ч нөхцөлд аврах үйл ажиллагаанд орж тавигдсан үүргийг амжилттай биелүүлж чадах боломжтой ба даалгасан үүргийг биелүүлэх талаарх тухайн нэгж, байгууллагын бэлтгэлжилтийн төвшинг тодорхойлон илэрхийлсэн үзүүлэлт байдаг³⁸.

Бэлэн байдлыг бүрдүүлэгч гол бүрэлдэхүүн нь бие бүрэлдэхүүний сэтгэл зүй, ёс суртахууны бэлтгэлжилт, дайчин чанар, аврагчдын сургалт бэлтгэл, сахилга бат, бие бялдын хатуужил, орчин үеийн аврах багаж, зэвсэг техникээр хангагдсан байдал, тэдгээрийн бүрэн бүтэн байдал, бүх шатны дарга нарын аврах бэлтгэлийн төвшин, чадвар, материал хэрэгслийн бүх төрлийн нөөц, хадгалалт, хамгаалалт, тээвэрлэлт зэрэг болно.

Бэлэн байдлыг хангахад удирдлагын байруудын бэлэн байдал шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг тул удирдлагын бэлэн байдал нь удирдлагын тогтолцоо түүний элемент нэг бүрийн болон хангалт үйлчилгээний анги, салбарын бэлэн байдал, жигдрэлт, штабуудын ажлын зохион байгуулалт, дайчин шуурхай ажиллагаа, захирагч, дарга нарын тактик, ар талын мэдлэг, ар талын хангалтыг зохион байгуулж удирдах өндөр чадвараар хангагдана.

³⁸ Цэдэв.П, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” ЭШӨ-2015 он.

Онцгой байдлын алба нь аврах өндөр хүчин чадал ихтэй багаж, техник, туулах чадвар сайтай, хурдтай техникээр хангагдаж, аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбаруудын аврах үйл ажиллагаа явуулах арга тактик өөрчлөгдөж, богино хугацаанд маневрлах боломж өндөр болсон орчин үеийн нөхцөлд цаг хугацааны хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэх болж байгаа бөгөөд энэ нь ар талын удирдлагыг шуурхай байхыг шаардаж байна.

Удирдлагын шуурхай байдлын үндсэн хэмжүүр нь удирдлагын ямар нэгэн мэдээлэл солилцох, бусад арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулах цаг хугацаа юм. Онцгой байдлын албаны үйл ажиллагаа нь гамшиг, ослын үед өдөр, цагаар хэмжигдэж байсан бол орчин үед минут, секундээр хэмжигдэж байна.

Аврах өндөр хүчин чадалтай багаж зэвсэг техник, Онцгой байдлын албанд нэвтэрч аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги, салбарын байлдааны ажиллагааны хурдац эрс өссөн орчин үеийн нөхцөлд удирдлага бат тогтвортой байх шаардлага тавигддаг.

Төрөл бүрийн удирдлагын бат тогтвортой, тасралтгүй байдлыг хангахын тулд удирдлагын байрыг зохион байгуулна. Гамшгийн голомт дахь цагийн байдал маш хурдан өөрчлөгдөж ар талын хангалтад ихээхэн нөлөө үзүүлэх боломжтой байдаг тул тухайн ар тал хангалтын албаны дарга, захирагч, захирагчийн орлогч-ар талын дарга нар цагийн байдлыг шуурхай зөв үнэлэн, ар талын хүч хэрэгслийг дээд зэргийн үр дүнтэй ашиглах хэрэгтэй. Үүний тулд шийдвэр хурдан гаргах, цаг алдалгүй үүрэг тавих, харилцан ажиллагааг шуурхай зохион байгуулах, ар талын хүч хэрэгслээр маневрлах, удирдлагаар найдвартай хангах ажиллагааг зохион байгуулна.

Ар талын хангалтын урьдчилан тогтоосон журамд өөрчлөлт оруулах, ар талын үндсэн чармайлтыг өөр чиглэлд шилжүүлэх, мөн ар талын анги, салбаруудын үүрэг гүйцэтгэх чадварыг сэргээх буюу ашигтай нөхцөл бүрдүүлэх зорилгоор ар талын хүч хэрэгслийг дахин бүлэглэхийг *ар талын хүч хэрэгслээр маневрлах* гэнэ.

Ар талын хүч хэрэгслээр маневрлах ажиллагааг дараах аргаар явуулна.
Үүнд:

- Материал хэрэглэл тээвэрлэн замд явж байгаа авто тээврийн ачаа хүргэх хаягийг шаардлагатай чиглэл рүү өөрчлөн сольж явуулах
- Анги, салбаруудын хооронд материал хэрэглэлийг дахин шинэчлэн хуваарилах
- Зарим анги, салбарыг хангалтын өөр эх үүсвэрт шилжүүлэх

- Ар талын анги, салбарыг ахлах даргын хүч хэрэгслээр хүч нэмэгдүүлэх, эсвэл тусгайлан гаргасан хангалтын бүлгээр хангалт хийх
- Ар талын анги, салбарыг түр шилжүүлэн захируулах.

Материал, техник, ар талын хангалтад тавигдах шаардлага:

Материал техник, ар талын хангалт нь тайван цагийн байдлаас гамшгийн үеийн байдалд богино хугацаанд шилжин, гамшгийн хор уршгийг арилгах явцад ар талын хангалтыг тасралтгүй зохион байгуулна.

Оперативын ар тал бүрэн дэлгэгдээгүй үед, түүнчлэн гамшгийн үед тусдаа чиглэлд ар талын хангалтыг өөрийн хүч хэрэгслээр бие даан үүрэг гүйцэтгэх чадвартай байх шаардлага тавигдана. Ар талын хангалтыг гүйцэтгэж байгаа аврах ангийнхаа адил хөдөлгөөнтэй, өөрийн хүч хэрэгслээр өргөн маневр хийх, ар талын хангалтыг тасралтгүй, найдвартай зохион байгуулах чадвартай байх ёстой³⁹.

Гамшгийн үеийн ар талын хангалтыг зохион байгуулах:

Ар талын хангалт цаг үеэ олсон, төгс байх нь түүнийг хэрхэн зөв зохион байгуулахаас шалтгаална. Ар талын хангалтыг зохион байгуулах гэдэг нь түүнийг бэлтгэх, ар талын байгууламжийг бий болгох, тээвэрлэлт-татан гаргалтын замыг бэлтгэх, бүх төрлийн материал хэрэглэлийг тээвэрлэх, авто тээврийг ашиглах журам тогтоох, төрөл бүрийн албадын үйл ажиллагаа, хүч хэрэгслийг тухайн ангийн ар талын хангалтад зохицуулах, ар талын харуул, хамгаалалтыг зохион байгуулах, удирдлагын системийг дэлгэх зэрэг цогц арга хэмжээг хэлнэ.

Ар талын хангалтыг зохион байгуулахдаа ар талын хүч хэрэгслийг уян хатан, зохистой ашиглах, ар талын анги салбаруудыг гамшгийн хөнөөлд аль болох бага өртөхөөр тооцох ёстой.

Аврах анги, салбаруудын ар талын хангалт түүний бэлтгэл ажлаас ихээхэн хамаарна. Гамшиг осолд аврагч нарыг бэлтгэх ажиллагаатай нэгэн зэрэг ар талын бэлтгэл ажил явагдах ба түүнд дараах арга хэмжээнүүд багтана. Үүнд:

- Ар талын анги, салбаруудыг бие бүрэлдэхүүн, техник хэрэгсэл, ар талын техник, сэлбэг, бусад эд хогшлоор нөхөн хангах
- Материал хэрэглэлийн нөөцийг тогтоосон хэмжээгээр нөхөн бүрдүүлэх
- Ар талын хангалтын төлөвлөгөөг албад, салбараар тодотгох
- Бүх төрлийн тооцоог хийж, ар талын хангалтын шийдвэр гаргахад бэлэн болгох
- Ар талын байгууламжийг бий болгох

³⁹ Төрмөнх.Ц “Цэргийн ар тал, техникийн хангалтын үндэс” 2016 он.

Гамшиг осол тохиолдсоны дараах аврах ажиллагааны явцад аврагч нарыг бүх төрлийн материал хэрэглэлээр шуурхай, тасралтгүй хангах зорилгоор зохион байгуулсан ар талын анги, салбаруудын хүч хэрэгслийн бүлэглэлийг ар талын хангалтын байгууламж гэнэ⁴⁰.

Ар талын хүч хэрэгслийг аврах ангийн бие бүрэлдэхүүний гүйцэтгэх үүрэг, газар орон, цаг агаарын байдал, ар талын анги, салбаруудын харуул, хамгаалалтыг зохион байгуулах боломж зэрэг олон хүчин зүйлийг харгалзан байрлуулна. Аврах ажиллагааны бэлтгэлийн явцад, ар талын гол үүрэг нь аврагч нарын бүх төрлийн материал хэрэглэлийн хангалтыг тасралтгүй, цаг тухайд нь, шуурхай зохион байгуулах, өвчтөн шархтан, нэрвэгдэгсэд эвдэрч, гэмтсэн техник хэрэгслийг татан гаргах, засаж сэлбэх юм.

Материал хэрэглэлийн тээвэрлэлтийг шуурхай зохион байгуулахад нөлөөлдөг нэг хүчин зүйл бол тээвэрлэлт татан гаргалтын замыг бэлтгэх, оновчтой ашиглах, тээвэрлэлт хийх нөхцөлийг бүрэн хангах хэмжээнд байнга байлгах шаардлагатай тул бүх төрлийн материал хэрэглэлийг аврагч нарт тээвэрлэн хүргэх, өвчтөн, шархтан, нэрвэгдэгсэд эвдэрсэн, гэмтсэн техник хэрэгслийг татан гаргах, иргэдийг нүүлгэн шилжүүлэхэд ашиглахаар гамшгийн бүсэд сонгон авсан буюу бэлтгэсэн замын сүлжээг тээвэрлэлт – татан гаргалтын зам / ТТГЗ / гэнэ.

Тээвэрлэлт татан гаргалтын зам үндсэн ба бэлтгэл, хөндлөн ба салбар замуудаас бүрдэнэ.

Тээвэрлэлт – татан гаргалтын замын тоо, чиглэл зэрэг нь ар талын хангалтыг зохион байгуулж буй алба хаагчид, цагийн байдал, гамшгийн улмаас үзүүлж болзошгүй нөлөөлөл, газар орны шинж, цаг агаарын байдал, ар талын цувааг хамгаалах боломж, тухайн аврах ажиллагаа явагдаж буй бүс нутгийн дэд бүтцийн хөгжил, шинээр зам бэлтгэх боломж зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Аврах ангиудын ар талын хангалтыг тухайн ангийн Удирдлагын ар талын байр-/УАТБ /-наас зохион байгуулна. УАТБ удирдлагын системийн нэг элемент бөгөөд ар талын хангалтыг, мөн бусад мэргэжлийн ангиудын техникийн хангалт, салбаруудыг удирдахад зориулан тусгайлан бэлтгэсэн удирдах байгууллагын ба албан тушаалтнуудын байр зарим тохиолдолд УАТБ удирдлагын зарим үүргийг гүйцэтгэнэ. УАТБ бүрийн бүрэлдэхүүн үүрэг нь тухайн анги, байгууллагын төрөл, гүйцэтгэх үүргийн шинж чанар, цагийн байдлаас хамаарна. УАТБ-ны удирдлагын бүрэлдэхүүнийг тодорхойлохдоо бие бүрэлдэхүүн, холбоо, автоматжуулалтын болон тээврийн хэрэгслүүдийг

⁴⁰ Цэдэв.П, “Онцгой байдлын үеийн ар тал хангалт” ЭШӨ-2015 он.

тухайн шатны удирдлагын байруудаар хуваарилсан тооцоон дээр үндэслэнэ. Энэ тооцоог штаб боловсруулж, командлагч (захирагч) батална.

Удирдлагын байранд дараах бүлгүүд багтана:

1. Удирдлагын бүлэг
2. Холбооны бүлэг
3. Хангалтын бүлэг

Ар талын хангалтын удирдлагын бүлэг нь ар талын хангалтыг удирдах байрын бүрэлдэхүүний үндсэн салбар юм. Энэ бүлэгт зөвхөн ар талын анги, салбар, байгууллагын удирдлагад шууд оролцдог удирдлагын байгууллагын албан тушаалтнууд ба техник хэрэгслүүд орно.

Энэ бүлгийн бүрэлдэхүүн :

1. Ар талын хангалтын удирдлагын төв (АТХУТ)
2. Техникийн хангалтын удирдлагын төв (ТХУТ) – оперативын төвшинд.
3. Төрөл, тусгай мэргэжлийн албадын дарга нарын удирдлагын байрууд, холбооны удирдлагын байр, Ар талын хангалтын удирдлагын төв ба Техникийн хангалтын удирдлагын төвийн техник хэрэгслүүд, харилцан ажиллагаа явуулж байгаа болон дэмжлэг үзүүлж байгаа ангиудын офицеруудын ажлын байр, шуурхай бүлэг, түүнчлэн удирдлагын бүлгийн бүрэлдэхүүнд ороогүй боловч Удирдлагын ар талын байранд байрлаж байгаа бусад бүлгүүдийн гишүүд орно.

Удирдлагын байрны холбооны бүлэг нь удирдлагын байруудад байнга буюу түр томилогдсон холбооны анги, салбарын хүч хэрэгслээс бүрдэх бөгөөд ар талын анги, салбаруудын удирдлагыг хангах үүрэгтэй.

Удирдлагын байрны холбооны бүлгийн бүрэлдэхүүн: холбооны иж бүрдэл хэрэгсэлтэй команд-штабын машинууд: сансрын ба радио релейний тусгай станцууд; шуудан-холбооны станц (тасаг), холбооны онгоц, нисдэг тэрэг буух талбай, цахилгааны тэжээлийн станцууд багтана.

Удирдлагын байранд ирэх мэдээллийн урсгал их байдаг тул даргын шийдвэрээр дан офицер бүрэлдэхүүнээр мэдээллийн бүлэг байгуулж болно. Энэ бүлэг нь Удирдлагын байранд ирж байгаа бүх мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх, нэгтгэх, боловсруулах, зориулалтаар нь хуваарилах, удирдлагын байгууллага болон албан тушаалтнуудад шуурхай дамжуулах үүрэгтэй.

Хангалтын бүлэгт үйлчилгээний бүх ажилтнууд орно: техник ба тээврийн хэрэгслүүдтэй бөгөөд удирдлагын бүлгийн тасралтгүй ажиллагаа, хоол, амралт, эмнэлгийн үйлчилгээ, удирдлагын техник хэрэгслийн засвар үйлчилгээ, удирдлагын байрны харуул хамгаалалт зэргийг хариуцна.

Мөн бүлэгт офицеруудыг амрахад зориулан тоноглогсон тусгай машинуудтай байх ба бүлгийн бүрэлдэхүүнд нь: хүнсний байр, эмнэлгийн байр, техник хангалтын байр, цахилгаан цэнэглэх станц, химийн ажиглалтын пост багтаж, харуул хамгаалалтын салбарууд, комендантын алба, инженерийн ба химийн салбарууд байна. Ямар ч тохиолдолд Удирдлагын байруудын бүтэц нь тэдний хөдөлгөөнт байдал, нууцлал, тогтвортой ажиллагааг хангахуйц чадвартай байх ёстой.

Онцгой байдлын байгууллагын техникийн хангалт нь тухайн гал түймэртэй тэмцэх анги, салбарын зэвсэглэл техникийн зөв ашиглалт, завсрыг сайтар зохион байгуулж, сэлбэг хэрэгслийн нөөцөөс ихээхэн шалтгаална.

Гамшгаас хамгаалах инженерийн хангалт гэдэг нь гамшгаас хамгаалах хүч хэрэгсэл байрлахад таатай похцол байдлыг бий болгох, тэдний маневрлах болон үүрэг гүйцэтгэх үеийн хөдөлгөөний саадгүй байдлыг хангах, хүч хэрэгслийн тогтвортой байдал, хамгаалалтыг сайжруулах болон төрөл бүрийн хөнөөх хэрэгслээс хүн амыг хамгаалах зэрэг цогц арга хэмжээ юм.

Дараах арга хэмжээнүүдээс инженерийн хангалтын амжилт шалтгаална.
Үүнд:

- Өгөгдсөн үүрэг даалгаврыг анги, салбарын дарга зөв ойлгосон эсэх;
- Бие бүрэлдэхүүний бэтгэлжилтийн түвшин;
- Инженерийн хангалтыг зохион байгуулах анги, салбарын бие даасан байдал;
- Нэмэлтээр гарсан инженерийн болон инженер - техникийн салбаруудыг чадварлаг ашиглах, тэдэнтэй нягт харилцан ажиллах;
- Газар орны байгалийн тогтоц, барилгын материал болон инженерийн техник хэрэгслийг чадварлаг ашиглаж байгаа байдал;
- Инженерийн хангалтын үүрэг даалгаврыг хүч хэрэгслийн бүрэн хүчин чадлаар биелүүлж байгаа байдал зэрэг болно.

Салбарын дарга нь инженерийн хангалтыг биечлэн зохион байгуулах бөгөөд гаргасан шийдвэртээ бүрэн хариуцлага хүлээнэ.

Инженерийн хангалтын үндсэн үүрэг нь:

1. Газар орон, объектод инженерийн тандалт хийх;
2. Гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн болон удирдлагын байр байрлах газар нутагт бэхлэлт хийх;
3. Нүүлгэн шилжүүлэлт болон хөдөлгөөн үйлдэх зам гарцуудыг бэлтгэх;
4. Усан саадыг гатлах гармуудыг тоноглох;
5. Инженерийн саад болон нурангид орц, гарц гаргах;
6. Газар орон, объект дахь тэсэрч, тэсрэх бодисыг аюулгүй болгох;
7. Ус олзворлох болон цэвэрлэх, усан хангамжийн цэгийг тоноглох,

8. байгуулах;
9. Инженерийн саад, нуранги үүсгэх (шаардлагатай тохиолдолд) зэрэг
10. болно.

Эдгээр үндсэн үүргээс гадна инженерийн хангалтын дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж болно. Үүнд:

- Аюултай объект болон аюул учруулж болзошгүй хоёрдогч хөнөөгч хүчин зүйлээс хүн ам, газар нутгийг хамгаалах;
- Болзошгүй дайны болон дайн бүхий байдлын үед эдийн засгийн чухал объект, хүн амыг өнгөлөн далдлах;
- Гамшгийн бүсүүдэд учирсан сүйрэл, усанд авталт, гал түймрийн голомтыг Онцгой байдлын албаны болон мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүний хүн, хүч хэрэгслийг дайчлан даван туулах, хязгаарлалт хийх хангалтыг зохион байгуулах;


Гамшгийн голомтод аврах ажиллагааг зохион байгуулах зэрэг болно.

Инженерийн хангалтын нарийн төвөгтэй үүрэг, даалгавар, бие бүрэлдэхүүний тусгай бэлтгэл, инженерийн |усгай техникийн ашиглалт зэргийг инженер - техникийн анги, салбарууд гүйцэтгэнэ.

Инженер техникийн болон бусад тусгай үүрэг, хүь ам, газар нутгийн хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Гамшгаас хамгаалах албадыг байгуулна.

Инженерийн эд хэрэгсэлд өнгөлөн далдлах хэрэгслүүд, зориулалтын хамгаалалтын байгууламжууд, тандалтын болон минэгүйжүүлэх иж бүрдлүүд ба бусад хэрэгслүүд, сургалт - дадлагын хэрэгслүүд, техникийн засварын хэрэгслүүд, техникийн бичиг баримт зэрэг зүйлс багтана.

Зураг 1. Гал түймэр унтраах, аврах ангийн үндсэн бүрэлдэхүүн, чиг үүрэг.




Гал түймэр унтраах аврах ангийн бэлэн байдал нь болзошгүй гал түймрийн үед түүний сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан

үүргийг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдлаар илэрхийлэгддэг. Өөрөөр хэлбэл томилгоот ээлжийн хүч хэрэгсэл ангийн байрлалаас гарч аврах, гал түймэр унтраах, анхны тусламж үзүүлэх үйл ажиллагаанд бэлтгэгдсэн байдлыг хэлнэ⁴¹.

Гал түймэр унтраах, аврах ангийн үүргээ гүйцэтгэх бэлэн байдал нь томилгоот бүрэлдэхүүн болон техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлаас шууд хамаарна.

Зураг 2. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлын хүчин зүйл



Томилгоот бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангах арга зүйн талаар авч үзье.

А. Томилгоот бие бүрэлдэхүүн

Томилгоот бүрэлдэхүүн гэж гал түймэр унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэлтэйгээр 24 цагаар үүрэг гүйцэтгэх гал түймэр унтраах аврах ангийн салааны захирагч, тасгийн захирагч, гал унтраах автомашин жолооч, Аврагч гал сөнөөгч, Шуурхай удирдлагын оператор зэрэг мэргэжлийн алба хаагчдыг хэлнэ гэж тодорхойлсон байна⁴².

Томилгоот бүрэлдэхүүний үүргээ гүйцэтгэх бэлэн байдал нь алба хаагчийн үүрэг гүйцэтгэх чадамжаас шууд хамаарна.

Мэдлэг ур чадвар, хандлага гурвын цогц нийлэмжийг чадамж гэж хэл болно.

Техник хэрэгсэл

Гал түймэр унтраах дүрмийн 10-р зүйлд “Гал түймэр унтраах үйл ажиллагааны хүч хэрэгсэл”-ийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Агаарын хөлөг, аврах болон гал түймэр унтраах зориулалтын техник, гал унтраах тусгай тоноглол бүхий автомашин, механик,(өөрөө авагч хэрэгсэл)

⁴¹ Билгүүн.З “Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдлыг дээшлүүлэх арга зам” 2018 он

⁴² Галын аюулгүй байдлын тухай хууль УБ 2015 он,- 3.1.13

шүхэр, гал түймэр унтраах автомат тоног төхөөрөмж, бусад гар багаж хэрэгсэл.

- Гал түймэр унтраах бодис (ус, хөөс, нунтаг, хий, бусад)
- Мэдээллийн болон холбооны хэрэгсэл
- Автомашин (тусгай тоноглол бүхий ус тээвэрлэгч)
- Гал түймэр унтраах зориулалтын инженерийн усан хангамж, усан сан багтана⁴³.

1-р зэрэглэл: Аймаг, нийслэл, сум дүүргийг хамгаалах 12 автомашинтай гал унтраах анги

2-р зэрэглэл: Аймаг, нийслэл, сум дүүргийг хамгаалах 9 автомашинтай гал унтраах анги

3-р зэрэглэл: Сум дүүргийн болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжийг хамгаалах 6 автомашинтай гал унтраах анги

4-р зэрэглэл: Сум дүүргийг хамгаалах 3 автомашинтай гал унтраах анги

Аймаг нийслэл, сум дүүргийн хүн амын тоо, нягтрал, үйлдвэржилт, дэд бүтэц, галын аюултай объектын цар хүрээ, онцлог, гал түймэр, гамшгийн давтамж зэргээс хамаарч гал унтраах анги, хэсгийг байгуулах ба гал унтраах зориулалтын үндсэн албаны автомашины тоог тодорхойлно⁴⁴.

Хүснэгт 1. Аймаг нийслэл, сум, дүүрэг дэх гал унтраах анги, хэсгийн үндсэн албаны автомашины тоо

Аймаг, нийслэл, сум, дүүргийн хүн ам	Гал унтраах ангийн үндсэн албаны автомашины (тоогоор)	Гал унтраах ангийн тоо
4000-6000 хүртэл	1	1
6001-10000 хүртэл	2	1
10001-15000 хүртэл	2-5	1
15001-20000 хүртэл	2-5	1-2
20001-50000 хүртэл	4-10	1-2
50001-100000 хүртэл	7-15	3-4
100001-500000 хүртэл	10-50	5-10
500001-800000 хүртэл	33-53	10-15

⁴³ Гал түймэр унтраах дүрэм УБ 2016 он, - 10-р зүйл

⁴⁴ Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавигдах шаардлага MNS 6412:2013

800001-1000000 хүртэл	50-56	16-18
1000001-1250000 хүртэл	53-65	18-24
1250001-2000000 хүртэл	56-80	24-36

Дээрх хүснэгтэд үзүүлсэн 10001-15000 хүртэл хүн амтай аймаг, нийслэл, сум, дүүрэгт 1 гал унтраах анги байхад, 50001-100000 хүртэл хүн амтай нэгжид 3-4 гал унтраах анги байх шаардлага байгаа нь харагдаж байна. Иймээс ихэнх дүүрэгт нэн шаардлагатайгаар хүн амын тоонд харьцуулан гал унтраах анги нэмэх шаардлагатай байгаа нь нотлогдлоо.

Дүгнэлт

Гамшгаас хамгаалах чадавхын гол үзүүлэлт нь техник, багаж хэрэгслийн хангалт гэж үзэж болно. Гал түймэр унтраах, аврах ангийн бэлэн байдал гэж болзошгүй гал түймрийн үед түүний сөрөг нөлөөллийг арилгахад чиглэсэн зохистой арга хэмжээг авах хүн хүч, техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангагдсан үүргийг гүйцэтгэхэд бэлтгэгдсэн байдлаар илэрхийлэгдэнэ.

Гал түймэр унтраах, аврах үйл ажиллагааны үед мөрдөгдөх эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалж үзэхэд 2004-2020 оны хооронд галын аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль болон Гал түймэр унтраах ажиллагаанд мөрдөгдөж ирсэн Гал түймэр унтраах дүрэм, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн дүрэм, Амьсгалын бие даасан төхөөрөмжтэй ажиллах үед дагаж мөрдөх дүрэм зэрэг эрх зүйн баримтаар зохицуулахаас гадна стандарт, нормын хүрээнд Гал түймэр унтраах аврах ангиудын үйл ажиллагаа зохицуулагдаж ирсэн байна.

Гал түймэр унтраах техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн норм стандарттай холбоотой эрх зүйн баримт бичиг Онцгой байдлын байгууллагад мөрдөгдөж байгаа нийт 51-н стандартын хүрээнд үйл ажиллагаа явуулж ирсэн байна. Онцгой байдлын байгууллагад ашиглагдаж байгаа нийт стандартыг задалж үзэхэд техник тоног төхөөрөмжийн хангалттай холбоотой 17 стандарт мөрдөгдөж байгаа хэдий ч Онцгой байдлын албаны үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, гамшгийн тоо хэмжээ өсөж буй өнөөгийн нөхцөлд хараахан шаардлага хангахгүй байна гэж дүгнэж болохуйц байна.

Судалгаанаас үзэхэд 10001-15000 хүртэл хүн амтай аймаг, нийслэл, сум, дүүрэгт 1 гал унтраах анги байхад, 50001-100000 хүртэл хүн амтай нэгжид 3-4 гал унтраах анги байх шаардлага байгаа нь харагдаж байна. Иймээс нийслэл хотын ихэнх дүүрэгт нэн шаардлагатайгаар хүн амын тоонд харьцуулан гал унтраах анги нэмэх шаардлагатай гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Гамшгаас хамгаалах тухай хууль, УБ 2017 он
2. Галын аюулгүй байдлын тухай хууль УБ 2015 он
3. Гал түймэр унтраах дүрэм УБ 2016 он
4. Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030 баримт бичгийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны хөтөлбөрт УБ 2018 он
5. Цэргийн ар тал хангалт 1995 он
6. Хилийн цэргийн ар талын хангалтын зарим асуудал 2005 он
7. Судалгааны ажлын эмхтгэл 2015 он
8. Гал унтраах анги, хэсэг, аврах нэгжид тавигдах шаардлага MNS 6412:2013
9. Онцгой байдлын байгууллагын гал түймэр унтраах тусгай зориулалтын тоноглол бүхий автомашинд тавих. Ерөнхий шаардлага CS 11-0425:2019
10. Гал түймэр унтраах даралтын хоолой. Техникийн шаардлага MNS 6576
11. Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл CS 11-0441:2020
12. Объектын гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас. Ерөнхий шаардлага CS 11-0439:2020